



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 137

Улаанбаатар хот

Г Үнэт цаасны өмчлөх эрхийг шилжүүлэх тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2 дахь заалт, Баянгол дүүргийн шүүхийн 2010 оны 954 дугаар захирамж, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2013 оны 02 дугаар сарын 15-ны 1/1542 тоот албан бичгийг тус тус үндэслэн, “Зоос банк” ХК-ийг Монголбанкнаас татан буулгах шийдвэр гаргасантай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн эдийн засгийн эрх ашгийг хамгаалах шаардлагатай байгааг тэмдэглэн, Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Зоос банк” ХК-ийн өмчлөлийн “Төмрийн завод” ХК-ийн 13,373 ширхэг энгийн хувьцааг өмчлөх эрхийг иргэн Т.Лувсандоржид шилжүүлэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

2. Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг шилжүүлэх ажиллагааг холбогдох үйлчилгээний шимтгэл, төлбөргүй гүйцэтгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН



000251